

БАТЛАВ  
НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН  
ДАРГА ..... Д.ОТГОНЖАРГАЛ

2023 он... 10 сар... 23 өдөр

УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ШИНЭЭР ХУДАЛДАН АВАХ ШААРДЛАГАТАЙ  
ДИЗЕЛЬ ХӨДӨЛГҮҮРТЭЙ, ИХ БАГТААМЖИЙН АВТОБУСНЫ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ БҮХИЙ  
АЖЛЫН ДААЛГАВАР

2023 оны 10 дугаар сарын 20

Улаанбаатар хот

№	Техникийн шаардлага	Их багтаамжийн автобусны үзүүлэлт	Үндэслэл	
1	Хууль, дүрэм, стандартын шаардлага	Монгол Улсын Автотээврийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020, "Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд" MNS 4599:2003, "Нийтийн тээвэр. Ангилал ба үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага" MNS 5012:2021, Монгол Улсын үндэсний стандартууд болон олон улсын бусад стандартын шаардлагыг бүрэн хангасан байна.		
2	Үйлдвэрлэсэн он	2023 онд үйлдвэрлэсэн	Шинээр үйлдвэрлэсэн байх	
3	Жолооны хүрдний байрлал	Зүүн талд байрлалтай (Зөв) байна.	Автотээврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг	
4	Багтаамж /зорчигчийн тоо/	Суудлын тоо	26-30 (+1)	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 5.8.1.1 дэх заалт Бүх жин
		Зогсоо зорчигчийн тоо	50-аас дээш	
		Нийт зорчигчийн тоо	80-аас дээш	
5	Оврын хэмжээ	Урт метр	10-11 м ( $\pm 0.5$ байж болно)	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 5.8.1.2 дахь заалт
		Өргөн метр	2.4-2.5 м ( $\pm 0,05$ м байж болно)	
		Өндөр метр	3,0-3,30 м ( $+0,05$ м байж болно)	
		Эргэлтийн радиус /R/	12 м-ээс ихгүй байна.	

6	Хөдөлгүүр	Дизель евро V (босоо байрлал)	2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 19/03 дугаар тогтоолын 1.1 дэх хэсэг
		Хөдөлгүүрийн эзэлхүүн 8400 cc дээш	Хэрэглээнд тохирсон
	Цилиндрийн тоо	6-8 гильзатай	Хөдөлгүүрийн багтаамжтай нийцсэн
	Чадал	280-350 морины хүч	Хөдөлгүүрийн багтаамжтай нийцсэн
7	Түлшний систем	Түлшний систем нь ус тусгаарлагч болон бусад механик хольцийг шүүж тунгаах цэвэрлэх төхөөрөмжтэй байх.	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 5.4 дэх хэсэг Орчин үеийн автотээврийн хэрэгслийн нийтлэг шаардлагад нийцсэн
8	Шатахууны савны хэмжээ	200 литр, түүнээс дээш	Хөдөлгүүрийн багтаамжтай нийцсэн мөн туулах маршрут замналтай нийцсэн
9	Дээд хурд	70 км/цаг (Хурд хязгаарлагчтай байж болно)	Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 12.4 дэх хэсэг
10	Хурдны хайрцаг	Автомат (АТ) болон механик (МТ)	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 5.4 дэх хэсэг Орчин үеийн автотээврийн хэрэгслийн хэрэгцээ шаардлагад нийцсэн дэвшилтэт
11	Тоормосны систем	Хийн систем, хүйтний улиралд (-45° C хүртэл) үл хөлдөх, урд, хойд тэнхлэг дискэн /Disc Brakes/ тоормос технологийн шийдэлтэй байна. Хийн систем нь автомат ус зайлуулагч, нэмэлт агаар халаагч, хуурайшуулагчтай байна.	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 5.4 дэх хэсэг Орчин үеийн автотээврийн хэрэгслийн хэрэгцээ шаардлагад нийцсэн техникийн хувьд дэвшилттэй, хийц загвар
		Автобусны зогсоолын тоормос нь 23.0 хувийн налууд уг автомашиныг хөдөлгөөнгүй барьдаг байх.	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 8.2.1 дэх заалт
		Дугуй	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 5.14.4, 5.14.5 дахь заалт

12	Тосолгооны систем	Автомат төвлөрсөн системтэй байх	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 5.4 дэх хэсэг Орчин үеийн автотээврийн хэрэгслийн хэрэгцээ шаардлагад нийцсэн техникийн хувьд дэвшилттэй, хийц загвар
13	Жолооны механизм	Шингэн хүчлүүртэй байна.	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 5.11.1 дэх заалт
14	Хаалга	Зорчигчид зориулсан хоёр хаалгатай байх ба хаалга бүрийн гадна дээд талд гэрэлтүүлэгтэй байна.	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 8.1.1 дэх заалт
15	Арал	Үндсэн арал нь ферм бүтэцтэй, тулгуур хэсгүүдэд хүчитгэж даацыг сайжруулж зэврэлтээс хамгаалагдсан байх.	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 5.4 дэх хэсэг Орчин үеийн автотээврийн хэрэгслийн хэрэгцээ шаардлагад нийцсэн техникийн хувьд дэвшилттэй, хийц загвар
16	Хана, тааз, шал	Автобусны хана, тааз, шалыг өвөл, зуны улиралд халуун, хүйтнийг тусгаарлах, галд тэсвэртэй материалаар хучигдсан байх бөгөөд битүүмжлэл сайтай байна.	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 5.4, 8.1 дэх хэсэг Орчин үеийн автотээврийн хэрэгслийн хэрэгцээ шаардлагад нийцсэн техникийн хувьд дэвшилттэй, хийц загвар
		Шал нь зорчигчийг гулгаж халтирахаас сэргийлсэн эдэлгээ даах материалаар хийгдсэн байна.	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 5.4 дэх хэсэг Орчин үеийн автотээврийн хэрэгслийн хэрэгцээ шаардлагад нийцсэн техникийн хувьд дэвшилттэй, хийц загвар
		Шалны түвшингээс дээш 1-3 гишгүүртэй байна.	"Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд" MNS 4599:2003 стандартын 5 дугаар зүйл Автобусны суудал, түшлэг, бариул, гишгүүр, шатны хэмжээсүүд
17	Шил	Салхины шил нь 3 хэсэг бүхий ойролцоогоор 6 мм-ын зузаантай аюулгүй наамал шил байна. Хажуу шил нь дээд болон доод хэсгээс бүрдэх бөгөөд аль нэг хэсэг нь гулсаж онгойдог, бууралттай, цантдаггүй, давхар (вакум), аюулгүй шил байна.	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 5.4 дэх хэсэг Орчин үеийн автотээврийн хэрэгслийн хэрэгцээ шаардлагад нийцсэн техникийн хувьд дэвшилттэй, хийц загвар

		Хажуу талын цонхнууд нь үл цантах шилтэй, гулсаж онгойдог, тэгш гадаргуутай байна.	
18	Жолоочийн хэсэгт	Жолоочийн бүхээг нь зорчигчдын танхимаас тусгаарлагдсан байна.	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага "MNS 4598:2020 стандартын 8.1 дэх хэсэг
		Жолоочид зориулсан салхивч, нарны халхавч (хаалт) болон өвөл, зуны улиралд халуун, хүйтнээр үлээх төхөөрөмжтэй байна.	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 8.4.3 дахь заалт
19	Суудал	Жолоочийн суудал нь аюулгүйн 3 цэгийн бүстэй, биеийн хэмжээнээс хамааруулан тохируулах боломжтой, биед чийг татахгүй, сайжруулсан тусгай материалаар хийгдсэн, суудал халаагч, хөрөгчтэй байна. Хийн болон шингэн зөөлрүүлэгчтэй байна.	"Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд" MNS 4599:2003 стандартын 6 дахь заалт
		Зорчигчийн суудал нь зорчигчийн биед чийг даахгүй, бат бөх, зөөлөвчтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан сайжруулсан тусгай материалаар хийгдсэн байна.	"Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд" MNS 4599:2003 стандартын 6 дахь заалт
20	Гүүшин холбоо (тэнхлэг)	Урд, хойд тэнхлэг хийн нум амортизатортай бөгөөд хийн нум тохируулагчтай байна.	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 5.4 дэх хэсэгт Орчин үеийн автотээврийн хэрэгслийн хэрэгцээ шаардлагад нийцсэн техникийн хувьд дэвшилттэй, хийц загвар
21	Хяналтын систем	Автобусны тоормосны болон цахилгааны системд гэмтэл гарах үед жолоочид мэдээлэх системээр тоноглогдсон байна.	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 5.4 дэх заалт Орчин үеийн автотээврийн хэрэгслийн хэрэгцээ шаардлагад нийцсэн техникийн хувьд дэвшилттэй, хийц загвар

22	Дулаацуулгын систем	Зорчигчдын зааланд 6-аас доошгүй халаалтын төхөөрөмжтэй байна. Зааланд нэмэлтээр урьдчилсан халаагууртай байна. /30кВт-аас багагүй/ Жолоочийн бүхээг хэсэгт халаагчтай байна. Урд салхины шил болон жолоочийн хажуу талын шилний цан үлээгч агаарын урсгал зохицуулагчтай байна. Гадна толь халдаг байна	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 8.1.3 дахь заалт
23	Агааржуулалтын систем	Салхивчтай байх бөгөөд агааржуулалтын систем нь зуны улиралд хүйтнээр үлээх төхөөрөмжтэй байна. Олон улсын хэллэг (Air condition)	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 8.1.3 дахь заалт
24	Ослын гарц	Ослын нэмэлт гарцтай байна.	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 8.1.3 дахь заалт
25	Гэрэл	Гэрлийн тусгалын чадлын хэмжээ 100000 cd-225000 cd байна.	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 6.3.1 дэх заалт
26	Нэмэлт шаардлага	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан шат, тавцан, автобусны тэргэнцэрийн бэхэлгээ стандарт шаардлага хангасан байна.	"Нийтийн тээвэр. Ангилал ба үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага" MNS 5012:2021 стандартын 10.5.1 дэх заалт
		Зорчигчийн бариулын өндөр шалнаас дээш 1800 мм-ээс ихгүй байна.	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 8.1.2 дахь заалт
		Зорчигчдод нийтийн тээврийн зогсоол зарлах чанга яригчтай байна.	"Нийтийн тээвэр. Ангилал ба үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага" MNS 5012:2021 стандартын 10.5.3 дахь заалт, "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 8.4.1 дэх заалт

	<p>Тээврийн хэрэгслийн урд, баруун, хойд гэсэн гурван талд гадагш харсан нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн дугаар, хаяг бүхий цахим дэлгэц самбартай байна. /LED, кирилл үсгийн санг дэмждэг байна/ Автобусны дотор талд зорчигчдод зориулсан дэлгэц /2 ширхэг/, урсдаг мэдээллийн дэлгэц (LED)-тэй байна.</p>	<p>"Нийтийн тээвэр. Ангилал ба үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага" MNS 5012:2021 стандартын 10.9.2, 10.14 дэх заалт</p>
	<p>Нийтийн тээврийн үйлчилгээний автобусанд хөдөлгөөний бүртгэл мэдээлэл, хяналт, зохицуулалтын нэгдсэн цахим системийн техник тоног төхөөрөмжийн суурилуулах, цахилгааны болон техникийн нөхцөлийг хангасан байна. Заалны чанга яригчтай байна.</p> <p>Заалны хяналтын камер нь 8 ширхэгээс дээш онлайн горимд ажиллах боломжтой байна. (Урд, хойно заал руу харсан, ухрах, урд зам, буух, суух хаалга руу харсан болон жолооч руу харсан байх, дуу, дүрс бичдэг байх)</p> <p>Камерын хяналтын системийн DVR төхөөрөмж нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- онлайн горимд ажиллах,</li> <li>- картны багтаамж 1ТВ-аас багагүй байх</li> <li>- нэмэлт 1-2 камер холбох оролт гаргах</li> </ul>	<p>"Нийтийн тээвэр. Ангилал ба үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага" MNS 5012:2021 стандартын 10.13, 10.3 дахь хэсэг</p>
	<p>Бусад ухаалаг системүүдтэй харилцан уялдах боломжтой байна.</p>	<p>"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 5.4 дэх хэсэгт Орчин үеийн автотээврийн хэрэгслийн хэрэгцээ шаардлагад нийцсэн техникийн хувьд дэвшилттэй, хийц загвар</p>
	<p>Зорчигчийн бариул нь цахилгаан гүйдэл дамжуулахгүй, тусгаарлагчтай, хүйтэнд хайрахгүй, цантахгүй байх</p>	<p>"Нийтийн тээвэр. Ангилал ба үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага" MNS 5012:2021 стандартын 10.1 дэх хэсэг "Авто тээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд" MNS 4599:2003 стандартын 2.1 дэх хэсэг</p>

		Цахим бүртгэл мэдээллийн төхөөрөмж холбох цахилгааны залгуурыг тусад нь бэлтгэх (12V, 24V)	"Нийтийн тээвэр. Ангилал ба үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага" MNS 5012:2021 стандартын 10.13 дахь хэсэг
		Зорчигчдод зориулсан бэлэн мөнгөний хайрцагыг байршуулсан байх	"Нийтийн тээвэр. Ангилал ба үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага" MNS 5012:2021 стандартын 10.13 дахь хэсэг
		Гар утас болон нэмэлт төхөөрөмж цэнэглэх (USB) байршуулсан байх, Мөн зорчигчийн хөдөлгөөнийг хянах дунд талын тольтой байх, хогийн савыг байршуулсан байх	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 5.4 дэх хэсэг Орчин үеийн автотээврийн хэрэгслийн хэрэгцээ шаардлагад нийцсэн техникийн хувьд дэвшилттэй, хийц загвар
		Хөдөлгүүрийн хэсэгт галын аюулаас урьдчилан сэргийлэх автомат гал унтраагчтай байна.	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 5.4 дэх хэсэг Орчин үеийн автотээврийн хэрэгслийн хэрэгцээ шаардлагад нийцсэн техникийн хувьд дэвшилттэй, хийц загвар
		Гал унтраагуур (5кг) 2 ширхэг, эмийн сантай байх	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 8.1.3 дахь заалт
		Жолоочийн бүхээгээс аккумуляторын цахилгаан гүйдлийг салгаж, холбох залгууртай байна.	"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 8.3.1 дэх заалт
		Автобусанд байрлах аюулгүйн санамж, анхааруулах зөвлөмж нь Монгол, Англи хэл дээр байна.	Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 5012:2021 стандартын 6.9 дэх хэсэг
27	Үйлдвэрлэгчийн итгэмжлэл буюу баталгаа	2 жил	Нийлүүлэгчээс гаргуулах баталгаа
28	Техник ашиглалт	Автобусны дагалдуулах хэрэгсэл (Нөөц дугуй, гар өргүүр, дугуйн дорцов, ивүүр, түлхүүр багаж, ослын зогсолтын тэмдэг, маслын шүүр, түлшний шүүр, агаар шүүгч)	Нэмэлт шаардлага
		Автобусны техник ашиглалт, засвар үйлчилгээ, аюулгүй ажиллагааны заавар Монгол хэл дээр, Сэлбэг хэрэгслийн катологи Монгол хэл дээр, Англи хэл дээр байна. Жолооч нарт сургалт арга зүйгээр ханган ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.	Нэмэлт шаардлага

	Их багтаамжийн автобусны техник ашиглалт, засвар үйлчилгээ, аюулгүй ажиллагааны талаар инженер, техникийн ажилчид болон жолооч нарт зориулсан сургалт дадлага хийх, туршлага судлах	Нэмэлт шаардлага
--	---	------------------

Боловсруулсан:  
Ажлын хэсгийн ахлагч



Б.Мөнхболд

Гишүүд:  
Техникийн хяналтын үзлэгийн төвийн ахлах менежер



Э.Өлзий

Автотээврийн хяналтын улсын байцаагч



Б.Одгэрэл

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын техник технологийн хэлтсийн инженер



Л.Цог

Нарийн бичгийн дарга:  
Техникийн хяналтын үзлэгийн төвийн инженер



Г.Ганбаатар